



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Улсын төсвөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд мэргэжлийн байгууллагуудаас тавих явцын хяналт сул байна.

*Ховд хот
2018 оны 4 сар*

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар.....2
ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....3
Дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрах	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ4
Аудитын менежер А.Цэцэгсүрэн	БҮЛЭГ -1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар <i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 ажилд 4424,7 сая төгрөг баталжээ.....5</i>
Ахлах аудитор Ц.Гантулга	БҮЛЭГ -2 Худалдан авах ажиллагааны талаар <i>Орон нутагт эрх шилжээгүй ТАХ-ны талаарх худалдан авах ажиллагааны мэдээлэл байхгүйгээс явцын хяналт хийхэд хүндрэл учирч байна.....7</i>
2018 оны 04 дүгээр сарын 18	БҮЛЭГ -3 Гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн талаар <i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний дутуу санхүүжилтийг тайланд онд олгожээ.....8</i>
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn	Ерөнхий дүгнэлт: Улсын төсвөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд мэргэжлийн байгууллагуудаас тавих явцын хяналт сул байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	Зөвлөмж.....13
ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын тамгын газар	Санал..... 14

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын газар
ХОАТАГ	Ховд аймгийн Төрийн аудитын газар
СЯ	Сангийн яам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭХС	Эрчим хүчний сайд
ХАА	Хөдөө аж ахуй
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ҮИ Н	Үйлдвэр, үйлдвэрлэл, нийлмэл
ШХА	Шууд хүлээн авах
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ЗГ	Засгийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв

-Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон иргэдийн өмчийн хөрөнгө оруулалтын төлөвлөх, тайлагнах журам”

- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”

- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Ховд аймгийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Ч.Галбадрах удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн явцын хяналт тавьж, аудитор О.Ариунзандан, аудитор Ц.Аззаяа нар 2016 оны 03-р сарын 15-наас 04-р сарын 16-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашгийн аудитын томилогдсон баг хөдөөгийн 3 сум, Аймгийн төвийн Эрүүл мэндийн газрын дээврийн болон цахилгааны засвар, гадна тохижилт, Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн сантехникийн засвар, Рашаант өрхийн эмнэлгийн барилгын ажлуудтай газар дээр нь ажиллаж танилцлаа.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар I бүлэгт, Худалдан авах ажиллагааны талаар II бүлэгт, гэрээний хэрэгжилт санхүүжилтийн талаар III бүлэгт танилцлаа.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль 2016 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-нд болон 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Аймгийн хэмжээнд 2017 оны төсвийн хуулиар улсын төсвийн хөрөнгөөр 11 ажил, арга хэмжээнд 2482,1 сая төгрөгийн санхүүжилт хийхээр баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтээс боловсролын салбарт 7 ажилд 886,9 сая төгрөг буюу 35,7 хувь, Эрүүл мэндийн салбарт 4 ажилд 1595,2 сая төгрөг буюу 64,3 хувийг хуваарилжээ.

Нийт хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээнүүдээс өмнөх онуудаас үргэлжилж буй 1, орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ажил 7 байна.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 ажилд 4424,7 сая төгрөг баталжээ.

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 377 тоот тогтоолын дагуу 2017 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд шинээр бүтээн байгуулалтын ажил байхгүй бөгөөд 2015-2016 онд төлөвлөгдсөн, улсын комиссоод хүлээлгэн өгсөн гүйцэтгэгч компаниудын дутуу санхүүжилт, засварын ажлыг 2017 оны төсөвт суулган хэрэгжүүлэхээр тусгажээ.

1.2 Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Ховд аймагт улсын төсвийн хөрөнгөөр тухайн онд шинээр эрх шилжин хийгдсэн их засварын ажил 8, нийт 14 ажил, арга хэмжээ хэрэгжжээ /сая.төг/

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	14	4424,7	4424,7
	Нийт дүн	14	4424,7	4424,7

1.3 Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 14 ажил, арга хэмжээ байгаагаас тухайн онд шинээр эрх шилжүүлсэн их засварын ажил 7, өмнөх оноос он дамжсан Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Рашаант өрхийн барилгын ажил, Булган сумын 50 ортой сум дундын нэгдсэн эмнэлгийн барилгын ажлуудын эрх орон нутагт шилжүүлжээ. Шинээр эрх шилжсэн засварын ажлуудыг хүснэгтээр харуулбал: /сая.төг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлэн хүлээн авсан байгууллагын нэр	Эрх шилжүүлсэн тушаалын		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Огноо	Дугаар		
1	Эрүүл мэндийн газрын барилгын дээврийн засвар, цахилгааны засвар	Ховд аймгийн Засаг дарга	2017.01.23	A/35	109.0	109.0
2	Дарви сумын цэцэрлэгийн засвар	Ховд аймгийн засаг дарга	2017.03.13	A/82	17.6	17.6
3	Булган сумын 2 дугаар сургуулийн барилгын засвар	Ховд аймгийн засаг дарга	2017.03.13	A/82	110.7	110.7
4	Дарви сумын сургуулийн барилгын хичээлийн байрны засвар	Ховд аймгийн Засаг дарга	2017.05.08	A/173	146.2	146.2
5	Дарви сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	Ховд аймгийн Засаг дарга	2017.05.08	A/173	88.4	88.4
6	Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн сантехникийн засвар	Ховд аймгийн Засаг дарга	2017.08.31	A/44	29.5	29.5
7	Мөст сумын сургуулийн барилгын засвар	Ховд аймгийн Засаг дарга	2017.08.31	A/44	50.0	50.0
	Нийт дүн				551.4	551.4

Зарим төлөвлөгдсөн ажил, арга хэмжээ нь аймаг, орон нутагтай ажлын уялдаа холбоогүйгээс үүдэлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад бүрэн хүртээмжтэй биш байна.

1.4 Хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ажлуудыг газар дээр нь аудит хийж байх явцад цаашид харьяа яам, газруудад асуудал тавьж шийдвэрлүүлэх зөрчлүүд арилахгүй байна. Тухайлбал:

- Хөшөөтийн 35 квт-ийн өндөр хүчдэлийн шугам, Жаргалант сумын төвд баригдах замын ажлууд, Жаргалант суманд байгуулагдах ХАА-н арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажил, Жаргалант сумын багуудад хийгдсэн цэвэр бохир усны шугамын ажлууд нь хэдийд хаана тендер зарлагдаж, хэдэн төгрөгний төсөвт өртөгтэйгээр ямар компани гүйцэтгэх болсон, одоо хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгаа, аймаг, орон нутагтай хэрхэн уялдаж хаанаас хяналт тавьж байгаа, эдгээртэй холбогдолтой бичиг баримтууд хаана хадгалагдаж байгаа, гүйцэтгэсэн ажлыг улсын комисс хүлээж авсан эсэх нь тодорхойгүй байгаа нь аудит хийж үнэлэлт, дүгнэлт гаргах боломжгүй хүндрэл учруулсаар байна.
- “Эе-Эвийн хүч” ОНӨААТҮГазрын барааны нэгдсэн захыг хүлээн авч үйл ажиллагаанд оруулаагүй өмчлөгчийн тодорхой хариуцах эзэнгүй маргаантай байгаагийн дээр аудитын тайлан гаргаж ирүүлээгүй энэ талаар шаардаж аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газарт албан тоотоор хандсан боловч хариу ирүүлэхгүй байна.
- Зэрэг сумын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй 5,0 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч “Ану сервис” ХХК-нь улсын төсвөөс санхүүжилтээ бүрэн авсан мөртлөө олон жил он дамжуулсаар 2017 онд сумын төвийн дулааны шугам сүлжээ, уурын зуухны ажлыг дуусгасан боловч гүйцэтгэлийг албан ёсоор улсын комисст хүлээлгэж өгөөгүй, цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг дутуу хийснээс багтаамжийн даац хэтэрч бохир хальж ард иргэдийн ундаалдаг ус горхи руу орж бохирдоход бэлэн болсон байгаа ба энэ талаар Зэрэг сумын ЗДТГ, аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс “Ану сервис” ХХК-нд удаа дараа хүсэлт тавиад асуудлыг шийдвэрлэж өгөхгүйгээр өдий хүрч байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Орон нутагт эрх шилжээгүй ТАХ-ны талаарх худалдан авах ажиллагааны мэдээлэл байхгүйгээс явцын хяналт хийхэд хүндрэл учирч байна.

- 2.1 Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд нийтдээ 2 тэр бум 433,1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 39 төсөл хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөнөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 922,9 сая төгрөгийн 11 ажил, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 879,5 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгожээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаанаас 43,4 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.
- 2.2 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 250,6 сая төгрөгийн 1 төсөл хөтөлбөрийн арга хэмжээнээс бусад бүх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулагдаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97,4 хувьтай байна. Засгийн газраас өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээл бүрдүүлэх хөрөнгийг аймагт шилжүүлж уг тендер шалгаруулалтыг оны төгсгөл рүү хуулийн дагуу нээлттэй тендер зарласан байна.
- 2.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу дээрхи 11 худалдан авах ажиллагааны 5-ыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 4-ийг харьцуулалтын аргаар, 2 тендер шалгаруулалтыг шууд худалдан авах аргаар хэрэгжүүлжээ.
- 2.4 Сум, орон нутаг, албан байгууллагууд худалдан авах ажиллагааг зохион байгуулах хүний нөөц дутмаг байгааг харгалзан худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжил арга зүйгээр хангах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах шаардлагатай байна. Мөн орон нутагт эрх шилжээгүй төсөл арга хэмжээний талаарх мэдээлэл байхгүйгээс явцын хяналт хийхэд хүндрэл учруулсаар байна.
- 2.5 Оны эхнээс төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу www.tender.gov.mn сайтыг захиалагч байгууллагууд болон тендерт оролцогчид бүрэн ашиглаж хэвшсэн тул худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны дийлэнх хувийг нь буюу төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхээр 43 төсөл арга хэмжээний төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг нийтэлсэний 24-ийг нь хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулжээ. Үндэсний өдөр

тутмын зууны мэдээ сонин, орон нутгийн телевизэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, шалгарсан болон шалгараагүй үндэслэл зэргийг тогтмол нийтэлсэн байна.

2.6 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах бүрт ил тод байдлыг индексийг бөглүүлж хэвшсэнээс гадна зураг төсөл, техникийн тодорхойлолт нь бэлэн болсон худалдан авах ажиллагааг тэр даруйд нь тендер шалгаруулалтыг эхлүүлж тендерийн үнэлгээг нээсэн үед нь хийж шуурхай зохион байгуулах бодлогыг баримтлан ажилласан байна.

БҮЛЭГ 3. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ , САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний дутуу санхүүжилтийг тайланд онд олгожээ.

3.1. Он дамжин хэрэгжүүлсэн ТАХ-ны хэрэгжилт зохих түвшинд байгааг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээр улсын комисс хүлээн авсан байна.

- Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг “Саруул цамхаг” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж 1365,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. Үүнээс 615,9 төгрөгийг 2017 онд санхүүжүүлсэнээр барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын “барилгын ажил зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байна.” гэсэн дүгнэлттэй 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 07/2017 тоот актаар хүлээн авсан байна.
- Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийн засвар, өргөтгөлийн барилга угсралтын ажлыг “АСЬФАКОНСТРАКШН” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж 200,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. Үүнээс 51,0 сая төгрөгийг 2017 онд санхүүжүүлсэнээр барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 2/13/2017 тоот актаар хүлээн авсан байна.





- Мөнххайрхан сумын төвд “Цэцэрлэгт хүрээлэн”-ийн хашаан дотор хүүхдийн тоглоомын талбайг “Эм Эн Жи Эм Эн” ХХК 10,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гүйцэтгэж Мөнххайрхан

сумын Засаг даргын А/145 тоот захирамжаар байгуулагдсан хүүхдийн тоглоомын талбай хүлээж авах комисс 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ШХА-ажил-2017/03 тоот актаар хүлээн авсан байна.

- Салбарын сайдын багцаас санхүүжих Алтай, Зэрэг, Мянгад, Эрдэнэбүрэн сумын ЭМТ-ийн халаалтын тогоо, халаалтын шугам шинэчлэх, халаалтын тогоо солих, Булган сумын нэгдсэн эмнэлгийн халаалтын тогоо жанам солих 42,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Эрүүл мэндийн сайдын эрх шилжүүлсэн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/429 тоот тушаалын дагуу аймгийн Эрүүл мэндийн газар дээр үнэлгээний хороо байгуулан тендер шалгаруулжээ. Уг тендер “Буянтын боргио” ХХК шалгарч аймгийн ЭМГ, “Буянтын боргио” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр ХОАЭМТ/20170003 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ гэрээндээ сайдын тушаалд заасан сумдыг бага зэрэг өөрчилөн нэг сум нэмж Ховд, Алтай, Мянгад, Эрдэнэбүрэн, Булган, Мөст сумдын ЭМТ-д ажил гүйцэтгэж 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 03 тоот актаар хүлээн авсан байна.

- Аймгийн Эрүүл мэндийн газар, Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт байрлах “Эс Жи Эм” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зарим сумдын Эрүүл мэндийн төвийн багийн эмч нарыг унаажуулах ЭМСЯ/201711129 тоот захиалагч, нийлүүлэгчийн гэрээ байгуулан гэрээнд заасан хугацаандаа /2017.12.20-2018.01.09-ний хооронд/ ЭМГ-т нэг бүрийг 1,8 сая төгрөгөөр 7 мотоцикл нийлүүлсэнийг Ховд сумын Цагаан бургас, Баруун салаа, Баянбулаг, Манхан сумын Зэрэг гол, Алтай сумын Барлаг баг, Мянгад, Чандмань сумын эмнэлэгүүдэд олгох хуваарьтай складанд хадгалаастай байна.

3.2. Он дамжин ашиглалтанд оруулах 1 ТАХ-ны хэрэгжилт зохих түвшинд хэрэгжиж байна.

- “Ховдын өргөө” ХХК гүйцэтгэх Булган сумын 50 ортой нэгдсэн эмнэлгийн барилга төсөвт өртгийнхөө 49,6 хувь буюу 2999,9 сая төгрөгийг 2017 оны жилийн эцсийн байдлаар



авсан барилгын ажил 3 давхар өрлөг хийгдсэн зохих түвшинд байна. Уг барилгыг 2018 онд ашиглалтанд оруулах юм.

3.3. Орон нутагт эрх шилжиж хийгдээгүй зарим ажлуудын хэрэгжилт тодорхой бус байна.

- Аймгийн төвийн хатуу хучилттай 5 км-ийн авто замыг “Түмэн дэлгэрэх” ХХК гүйцэтгэж байгаа ба 2016 онд улсын төсвөөс 725,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч энэ замыг хүлээлгэн өгсөн, хүлээн авсан талаархи бичиг баримт байхгүй байна. Дээрхи ажлыг ашиглалтанд хүлээн авах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/379 тоот захирамжаар байгуулсан хэдий ч захирамжийн биелэлт хангагдаагүй байна.
- Мөн “Түмэн дэлгэрэх” ХХК –ны гүйцэтгэх Жаргалант сумын төвд баригдах хэсэгчилсэн 3.874 км хатуу хучилттай авто замын талаар Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн удирдамжаар тус яамнаас ажлын хэсэг гарч баруун аймгуудад томилолтоор ажиллахдаа аймгийн Засаг даргын орлогчоос хүргүүлсэн албан хүсэлтийн дагуу тус компанийн гүйцэтгэж байгаа замын шинэчлэлтийн ажлын явц, байдалтай 2017 оны 10 дугаар сарын 14-ний танилцаад захилагчийн зөвшөөрөлгүй, зураг төсөл зөрчиж ажил гүйцэтгэсэн, одоо хийгдэж байгаа 1,12 км авто замын хашлаганы бат бэх хангалтгүй, хугарч эвдэрсэн, муруй сарий, өндөр нам тавигдсан, асфальтбетон хучилт, хэвтээ хашлага хоёр өндөр зөрүүтэй байсан зэрэг зөрчил дутагдал илэрснийг засаж , биелэлтийг ЗТЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлэхийг үүрэг болгожээ. Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/419 тоот захирамжаар авто замын барилгын ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан хэдий ч авто замын ажлын явц, харьяа яамнаас өгсөн үүргийн биелэлт, энэ талаар гүйцэтгэгч компанитай хариуцлага тооцсон зэрэг ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.
- Барилга, хот байгуулалтын яамны 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн гэрээ байгуулах эрх олгох тухай 03/2069 албан тоотын дагуу БХБЯ-тай “Ховдын өргөө” ХХК 642,2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Ховд аймгийн төвд хийгдэх цэвэр ,бохир усны 15 км шугамын шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын эхний ээлжийн ажлын БХБЯ-А-2017/002 тоот ажил гүйцэтгэх гэрээг 2017 онд байгуулжээ. Гэрээндээ уг ажлыг 2017 оны 08 дугаар сарын 01-ны өдөр эхэлж, 2018 оны 05 дугаар сарын 20-ны

өдөр ашиглалтанд оруулахаар тусгасан байна. Гүйцэтгэгч компани 2017 онд Жаргалант сумын Алаг толгой, Хайрхан, Тахилт багийн нутаг дэвсгэрт шинээр 3 км цэвэр, бохирын шугамын барилга угсралтын ажил хийж гүйцэтгэсэн гэсэн ажлын зураг баримт байна. Үүнд аль ч шатны явцын хяналт хийж үнэлэлт, дүгнэлт, үүрэг даалгавар өгөгдөөгүй байна.

- Жаргалант суманд байгуулагдах Арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг “Сан” ХХК-ниас хүлээн авах комиссыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/425 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар, хүлээн авсаны дараа Ховд аймгийн ЗДТГ-т хүлээн авсан актын дагуу хүлээлгэн өгч, хүлээлцсэн акт үйлдэх ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар үүрэг болгосны дагуу 2014 оны 9дүгээр сарын 04-ний өдрийн 01 тоот актаар “Сан” ХХК-ниас уг тоног төхөөрөмжийг хүлээн авч, хүлээлгэн өгсөн байна. Энэ ажлын хэсгийн бүрэлдхүүнд аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга орсон. Харин аймагт тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг Ховд аймгийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/21 тоот захирамжаар байгуулсан боловч захирамжийн хэрэгжилт хангагдаагүй өдий хүрчээ.
- Хөшөөтийн уурхайгаас Үенч сум хүртэл 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцыг өргөтгөх ажлыг Жаргалант суманд байрлах “Алтай трест” ХХК техникийн нөхцөлөө 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 96/2017/22 тоотоор тодорхойлж Эрчим хүчний яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар батлуулан Үенч, Цэцэг, Алтай сумын Засаг дарга нар газар олгох тухай захирамж гаргасан байна. Энэ ажлын явцын талаар өөр тодорхой мэдээлэлгүй байна.
- “Хүчит чулуут” ХХК-ны гүйцэтгэсэн талын хашааны цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөл, их засварын ажил 2012 онд 2015 оны 11 сарын 11-ны өдрийн 48/2015 тоот улсын комиссын актаар хүлээн авсан боловч ашиглагч байгууллага чанаргүй хийгдсэн шалтгаанаар хүлээж авахгүй өдий хүртэл дуусаагүй барилга “нэртэй” тайлан балансад тусгасаар байна.
- Бельгийн Вант Улсын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж баригдах “Баруун бүсийн эмчилгээ оношлогооны төвийг сайжруулах” төслийн хүрээнд 2016, 2017 он дамжуулан 1993,0 сая төгрөгийн санхүүжилтийг вексел, концессээр авсан гэх боловч холбогдох баримт материал орон нутагт

олдохгүй байгаа ба аймгийн БОЭТ-д баригдаж буй барилга байгууламж байхгүй байна.

- Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн хүрээний олон багцад хамрагдах 2018 онд ашиглалтанд орох хугацаатай Өлгий-Ховд чиглэлийн хатуу хучилттай 189.7 км-ийн авто замын ажил үргэлжилж байна

3.4. Орон нутагт эрх шилжиж 7, гүйцэтгэгч компани захиалагч байгууллагатай шууд гэрээ байгуулан 1 бүгд 8 их засварын ажил хийжээ.

- Тайлант онд Эрүүл мэндийн газрын барилгын дээвэр, цахилгааны засвар, Дарви сумын цэцэрлэгийн засвар, Булган сумын 2 дугаар сургуулийн барилгын засвар, Дарви сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар, Жаргалант сумын нэгдүгээр сургуулийн сантехникийн засвар, Мөст сумын сургуулийн засвар, Эрүүл мэндийн газрын барилгын гадна тохижилтын засварын ажлууд хийгдсэн байна.


3.5. Холбогдох мэргэжлийн байгууллагуудын явцын хяналт сулаас зарим ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудит хийх явцад, хэрэгжүүлсэн ажлуудыг газар дээр нь хянахад ашиглалтанд хүлээн авсаны дараахь барилгын засварын ажлын чанар хангалтгүй байна.

Тухайлбал:

- “Буянтын боргио” ХХК-ны

гүйцэтгээсэн Дарви сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажлыг улсын



комиссын гишүүдийн олонхийн саналаар үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авчээ. Дотуур байрны барилгын засварын ажлын талаар гүйцэтгэгч компанид комиссоос өгөгдсөн дотор заслын ажлыг замаскан будгаар хийснийг зургийн дагуу эмulsion будгаар хийх, зөвхөн 2 хавтастай хаалгыг модоор бусдыг нь ислэг хавтангаар хийснийг бүгдийг модон хаалгаар солих, агааржуулах салхивчны сараалжин торыг солих,



тасаг , коридоруудыг нимгэн хулдаасаар хулдаасалсаныг стандартын хулдаасаар солих зэрэг үүргийг биелүүлээгүй байлаа. Дээрхи үүрэг хэрэгжээгүйгээс хулдаасан шал элэгдэж цоорсон, тасаг өрөөний хаалганууд холцорсон, дотуур байрны галлагааны хаалганы довжоо хийгдээгүй байна. Уг барилгын засварын ажлыг гүйцэтгэсэн компанид илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар хугацаатай албан шаардлага өглөө.

- “Жигүүр эрдэнэ” ХХК гүйцэтгэсэн сургуулийн хичээлийн байрны нүүрэн талын будаг зарим газар ховхорсон, цаашдаа салхи, бороонд талбайн хэмжээ нь ихсэх байдалтай байна.



- “Саруул цамхаг” ХХК-ны гүйцэтгэсэн цэцэрлэгийн барилгын дээврийн засвар нь ажил хүлээлгэн өгсөнөөс хойш анхны цас ороход дээврийн зарим хэсгээр ус орж ирсэнийг гүйцэтгэгч компанид мэдэгдэж засуулсан ч дахин ус дусаал орж байгаа тухай байгууллагын удирдлага ,багш нар тайлбар өгч байлаа.



Аудитаар төлбөрийн акт үйлдээгүй, ажил гүйцэтгэгч компаниудад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Бүлгийн дүгнэлт:

- **Зарим төлөвлөгдсөн ажил, арга хэмжээ нь аймаг, орон нутагтай ажлын уялдаа холбоогүйгээс үүдэлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад бүрэн хүртээмжтэй биш байна.**
- **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний дутуу санхүүжилтийг тайланд онд олгожээ.**

- **Холбогдох мэргэжлийн байгууллагуудын явцын хяналт сулаас зарим ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.**

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Улсын төсвөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд мэргэжлийн байгууллагуудаас тавих явцын хяналт сул байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Галсандондог-т зөвлөх нь:

- Орон нутагт зарласан тендерт хамрагдаагүй эрх авнааг орон нутагт байгаа буюу ажлын гүйцэтгэлийн талаар бодвол үзвэл, орон нутагт ажлын гүйцэтгэлийн талаар бодвол үзвэл нь мэдээлж хамтран ажиллах
- Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажил, ТАХ-ний талаар нэгдсэн мэдээллийн сантай болох

Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга М.Отгонханд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Гомбосүрэн нарт зөвлөх нь:

- Орон нутагт ажлын гүйцэтгэлийн талаар бодвол үзвэл, орон нутагт ажлын гүйцэтгэлийн талаар бодвол үзвэл нь мэдээлж хамтран ажиллах
- Тендрээр шалгарсан аж ахуйн нэгжүүдэд ажил үйлчилгээнийх нь талаар бодвол үзвэл, орон нутагт ажлын гүйцэтгэлийн талаар бодвол үзвэл нь мэдээлж хамтран ажиллах
- Шинээр хэрэгжсэн ТАХ-үүдийн хөрөнгийн ИТХ-д танилцуулж шийдвэр гаргуулан тухай бүр данс бүртгэлд тусгуулж байх.
- Оны эцэст дуусаагүй ажил, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэнд гүйцэтгэлийн баталгааг харилцагч банкинд гаргаж өгөх замаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг бүрэн зарцуулах боломжийг бүрдүүлэх

- Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжэнүүдийн ажлыг хариуцдаг Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн ажилтан, мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхой болгож, биелэлтэнд тавих хяналтыг чангатгах

САНАЛ

1. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээлийн хүрээнд “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд БСШУС-ын яам, ЗИ-ТИ-И корпораци хооронд байгуулсан гэрээний дагуу Дөргөн, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Мөст, Ховд, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн, Үенч сумдын сургуулиудад сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэгдэж сайдын А/362 тоот тушаалын дагуу үнийн залруулгаар хөрөнгөнд бүртгэн авчээ.
2. Эрүүл мэндийн байгууллагууд хөрөнгөнд бүртгэж аваагүй. Эрүүл мэндийн яам албан ёсоор хүлээж аваагүй тул 2017 оны санхүүгийн тайланд орлого авахгүй гэсэн шийдвэрийг яамнаас ирүүлсэн гэж тайлбар өгч байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.ГАЛБАДРАХ
А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ГАНТУЛГА